

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ЭНЭТЭМНИЙН УХЛААНЫ ФАКУЛЬТЕТ

# ТҮҮЖ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ № 488 (14) 2002 он

RUSSIA



# Гарчиг

## Эрхэм уншигч Танаа

5

### Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

### Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

### Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

### Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

### Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

### Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

### Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

## Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь

Доктор /Ph/, дэд профессор Н.Хишигт  
/ШУА. Түүхийн хүрээлэн/

Байгуулсан гавъяа, үйл ажиллагаагаараа бусдын хувь заяанд чамгүй үүрэг гүйцэтгэж, түүхэнд нэрээ мөнхлөгсдийн зэрэгцээгээр цаг үе, нөхцөл байдлын улмаас аль нэг улс үндэстэн хэн нэгнийг ч мөн түүхэнд гарган тавих нь байх аж. Тийм нэгэн бол барон фон Унгерн Штернберг юм. Түүний нэрийг XX зууны Монголын түүхийн богинохон боловч нэн ээдрээтэй үе дэлхий дахинд танил болгосон билээ.

Монгол орны тусгаар тогтнолын сүүлчийн найдвар болсон автономит засгийг хятад цэрэг хүч түрэн устгаж өөрсдийн харгис дэглэмийг тогтоосон нөхцөлд монголчууд харийн дарлалаас ангижрах арга замыг зүйл бүрээр эрэлхийлж байлаа. ЗОУ-аас тусламж олохоор одсон МАН-ын төлөөлөгч С.Данзан, Д.Чагдаржав нарын зорьсон хэрэг бүтэж Зөвлөлт засгийн газраас монголчуудад дэмжлэг үзүүлэхээр амалсан цаг мөчид Монгол орны улс төрийн байдлыг өөрчилсөн нэгэн үйл явдал тохиосон нь Улаан армийн давшилтанд шахагдсан цагаан цэргийн нэг хэсэг тус оронд цөмрөн орж ирсэн хэрэг байлаа. 1920 оны X сарын 2-нд Монголын зүүн хязгаарын Улз, Онон голын сав нутаг, Гилбэр харуулаар нэвтэрсэн тэрхүү цэргийг “Нармай Монголын хөдөлгөөн”-ийг зохион байгуулагчдын нэг, Өвөр Байгалийн атаман Г.Семёновын хамсаатан асан барон Унгерн захирсан байв.

Дорнод Сибирийн улс төрийн үйл явдал хийгээд 1921 оны монголын хувьсгалын түүхтэй холбоотойгоор бараг бүтэн зууны туршид янз бүрээр хэлэгдсэн энэхүү барон Унгерн гэгч хэн бэ?. Тэрбээр Аттил хааны үеийн хүннүүд болох мажааруудтай цус холилдсон германуудаас гаралтай эртний язгуурт Унгерн фон Штернбергийнхний удмын хүн болохоо 1921 оны хавар Монголын Нийслэл Хүрээнд уулзсан А.Ф.Оссендовски гэгчид өгүүлсэн байдаг. Тэрхүү польш хүний бичиж үлдээсэнээр Унгерний өвөг дээдэс Загалмайтны аян дайнд оролцож, Төвтоны ордыг байгуулалцан, XVI – XVII зуунаас Латви, Эстонид эзэмшил шилтгээнтэй байж, зарим нэг нь далайн дээрэм эрхэлж, нөгөө нэг нь хувилахуйн ухаан судлан элдэв төрлийн туршлага хийдэг байжээ<sup>1</sup>. Өвөг эцэг нь Энэтхэгийн далайд дээрэм хийж Английн усан онгоцнуудаас гувчуур авч байснагаа төлөө Монголын хилд ойрхон орших Байгаль нуурын хавьд цөлөгджээ. Тэрбээр Штернбергийнхний удмын дундаас анх түрүүнд Алс Дорнодод хөл тавьсан нэгэн бөгөөд буддын шашныг судалж байсан нь хожим нь ач хүү Роман Унгернд багагүй нөлөөлсөн аж. Харин эцэг нь рыцари, далайн дээрэмчид, мистикүүдээс бүрдсэн удмынхныхаа дотор төдийлэн алдартай байсангүй.

Арван наймдахь үеийн Роман Унгерн Австрийн Граце хотод 1885 оны XII сарын 29-нд төржээ. Эцэг эх нь анхлан Грегорийн хуанлиар бүртгүүлсэн ч дунд сургуульд ороход нь шинэ тооллыг алдаж тооцсоноос төрсөн өдрийг нь хожмын баримт бичигт 1886 оны 1 сарын 22-оор бичих болсон аж. Үүний зэрэгцээгээр зарим нэгэн ном зохиолд Унгернийг 1887 онд төрсөн<sup>2</sup> гэж

<sup>1</sup> Ф.Оссендовски. Хүн, араатан, бурхад ( Дамбийжаа, барон Унгерн хийгээд Загастайн савдаг. Диваажингийн тухай 1921 оны аян замын эрэгцүүлэл- тэмдэглэл ). орч. Ж.Нэргүй. УБ., 2000. т.216-217.

<sup>2</sup> А.Стольпин. Москва Бээжингийн завсар дахь Монгол орон. ( Орч Л.Бат-Очир ). УБ., 2000. т.51 “ Барон Унгерний тухай”-Академич Х.Пэрлээ. Эрдэм шинжилгээний өгүүлүүд”. Б.1. УБ., 2001. т. 32.

тэмдэглэсэн нь ч бас буй. Тухайн цагийн герман гэр бүлд тархсан уламжлалаар түүнд Роберт-Николай-Максимилиан хэмээх нэрийг өгсөн боловч Николай-Максимилианыг гэж Робертыг-Роман, эцгийн Теодоровичийг-Феодорович болгон хэрэглэсэн аж. Гэвч түүхэнд зөвхөн барон Унгерн гэсэн нэр үлдсэн билээ. Унгерний эх нь Софи-Шарлотте фон Вимпфен гэгч ихээхэн өв хөрөнгөтэй бүсгүй байжээ. 1891 онд эцэг эхээ салсаны дараагаар хүү эхтэйгээ үлдэж, гурван жилийн дараанаас Ревель (эдүгээгийн Таллин-Н.Х) хотноо хойт эцэг барон Оскар Хойнингений гэрт амьдарч байв. Унгерн нэгэн үе Ревель хотын гимназид сурч байгаад хөөгдөж, 1896 онд Петрбургийн усан цэргийн сургуульд элсэн оржээ. XX зууны анхны томоохон байлдаан болох Орос-Японы дайн эхэлсэнийг дуулмагц багын адал явдал, алдар гавъяаг мөрөөдөгч тэрбээр дуулмагц фронтод явахаар шийдэж төгсөхөөсөө нэг жилийн өмнө сургуулиа орхин, явган цэргийн хороонд байлдагч болжээ.

Гэвч Унгернийг Алс Дорнотод хүрч очиход дайн хэдийнэ дууссан байсан тул төрөлх нутагтаа буцаж Павловын явган цэргийн сургуульд оржээ. Хожим генерал П.Н. Врангелийн ярьсанаар Унгерн 1908 онд "офицерийн шалгалтыг арай ядан даваад"<sup>3</sup> Хятадын хил ба Читийн хооронд оршин төмөр замын Даур өртөөнд байрлаж байсан Өвөр Байгалийн хасаг цэргийн Аргуны хороонд очжээ. Тэнд Унгерн морь сайн унаж сурсанаар морин цэргийн офицер болох замаа эхэлж хэзээ ч үл ядрах тэсвэр хатуужлыг олсон аж. Төдий л удалгүй мөн л хэрүүл шуугианы улмаас Даурын хорооноос хөөгдөв.

Энэ удаа тэрээр Ерөнхий штабын ажилтан байсан эцгийн талын хамаатан ба төрөл садны холбоотой генерал Ранненкамфн нарын тусламжтайгаар Аргунаас Амарын хороонд шилжих тушаал авчээ. Дауриас явахынхаа өмнө Унгерн "... Амарын хороо байрлах Благовещенск (одоогийн Хабаровск-Н.Х) хүртэлх 400 гаруй мод газрыг дан мориор, олдсоноороо хооллон туулах"-аар хорооныхоо офицерүүдтэй туулахаар мөрий тавьж биелүүлжээ. Гав ганцаар зэлүүд нутгаар хэрэн тэнэж, тушаалын газар хүрч очсон түүний чухам хаагуур явж юу хийсэн нь төдий л тодорхой бус ч зарим нэгэн мэдээгээр Монголтой холбогдох сэжим буйг хойно өгүүлмүй. Алс Дорнот дахь хасаг цэргийн цорын ганц орон тооны хороо байсан Амарын хороонд очоод Унгерн анх пулемёт бууны суманд томилогдож, удалгүй 1-р зуутын тагнуул ангийн даргаар дэвшжээ. Шинэ газар адал явдал, дайны хэнээтэн Унгернд гавъяа байгуулах боломж мөн л хомс байсан тул хуарангийн нэгэн хэвийн амьдралд уйдаж гүйцсэн тэрбээр 1911 онд хагас жилийн хувийн чөлөө авч нутаг буцжээ. Түүнийг Ревелээс 1912 оны эхээр Благовещенскт ирэхэд Манж Чин гүрэн унаж, түүний оронд Хятадын бүгд найрамдах улс буй болж, нэгэн үе дэлхийг донсолгосон Чингисийн удмын монголчууд тусгаар улсаа дахин байгуулсан, тэр ч бүү хэл Монголд хаант Оросын сургагч нарын оролцоотойгоор цэргийн сургууль байгуулж эхэлсэн зэрэг "онцгой таатай" мэдээ угтжээ. Унгерн шууд л Монголд явуулахыг хүссэн боловч татгалзсан хариу авсан тул чөлөөнд гарч хувийн журмаар алба хашихаар шийдэж, 1913 оны YII сард чөлөө хүссэн өрөгдөл бичиж Петрбургт илгээв. Таван сарын дараагаар зуутын дарга Унгернийг "дүрэмт хувцас, тэтгэлэггүйгээр чөлөөнд гаргах тухай тушаал" Петрбургээс ирэхэд тэрээр аль хэдийнэ Монголд очсон байв.

1914 онд дэлхийн анхдугаар дайн эхлэхэд Унгерн төрөлх хотдоо байсан бөгөөд мөнгө хөрөнгө, гэр бүл, ажил албагүй байсан түүнд дайн алдар гавъяанд хүрэх шинэ боломж нээнэ хэмээн горилж бүхнээс түрүүнд фронтод явав. Унгерн

<sup>3</sup> А. Столыпин. Нэр дурдсан зохиол. т 51-52.

бүтэн гурван жилийн турш фронтын тэргүүн эгнээнд байлдаж, дөрвөн удаа шархдан, цагаан хаанаас эр зоригийн төлөө олгодог гэгээн Георгийн загалмай зүүж, ариун Аннын 3-р зэргийн одон хүртсэн ч зуутын даргаас дээш дэвшсэнгүй. Мөн үед түүний хувь заяанд багагүй нөлөөлсөн Георгий Семёновтай танилцжээ. Архинд автагдсан, зожиг бүдүүлэг зантай Унгерн Румыний фронтоос Георгийн одонтуудын уулзалтанд оролцохоор Петрбург орох замдаа Тернополь хотын комендантын туслахыг зодсон хэргээр шийтгэгдэх болсон авч хуучин дарга, П.Н.Врангель "бэлтгэл ангид шилжүүлэх тушаал"<sup>4</sup> гарган аварчээ. Үүгээр хаант Оросын армийн өмнө түүний байгуулах гавъяа дууссан боловч түүхэнд нэрээ үлдээх боломж чухам энэ үеэс нээгдсэн гэлтэй.

1917 оны Оросын хувьсгал хаант ёсыг агштал баримтлагч Унгернд хүнд цохилт болж, тэрбээр ирээдүй хойчоо төсөөлөх аргагүй болсон<sup>5</sup> ч дахин аз тохиосон нь генерал Корниловын тушаалаар мөн оны наймдугаар сард Ревелээр дайран өнгөрсөн Усурийн дивизэд орж, улмаар Өвөр Байгальд хүрсэн явдал байв. Өгүүлэн буй үед Керенскийн Түр засгийн газраас Өвөр Байгалд томилогдсон Г.М.Семёнов Сибирээс Түвэд, умард Манжуур хүртэлж өргөн уудам газар нутгийг хамарсан "Нармай Монгол улс"-ыг байгуулахыг зорьж, сайн дурынхнаас бүрдсэн Манжуурын тусгай отряд гэгчийг эмхэлж байлаа. Өөрийг нь зорьж очсон "эрэлхэг зоригтой" фронтын танилаа атаман Хайлаарын төмөр замын өртөөний комендантаар томилж, удалгүй өвөрлөгч ноён Фушанга (Буяндэлгэр болов уу - Н.Х)-гийн цэргийн зөвлөх болгожээ<sup>6</sup>. Дашрамд тэмдэглэхэд, тэрхүү Фушанга болон барга Фушан нар 1919 оны II сард Даурт болсон "Нармай монголын хурал"-ын үеэр Манж Чин гүрнийг сэргээн мандуулах тэмцлийн асуудлыг дэвшүүлэн тавьж байсан нь<sup>7</sup> Унгерний үзэл бодлын нөлөө ч байж болох юм. Гэхдээ Унгерн Их Чингисийн эзэнт гүрний суурин дээр өрнөдийн загвараар улс байгуулах гэсэн пан монголын үзэлтнүүдэд төдийлэн таатай хандаж байгаагүйг тэмдэглэх ёстой.

Барон 1918 оны IX сараас 1920 оны X сарын эх хүртэл Даурт байжээ. Унгерний Даурын амьдралд тохиосон онцгой үйл явдал бол тэрбээр 1918 оны VIII сарын 16-нд манж гүнжтэй гэрлэсэн явдал юм. Дорно дахины эзэнт гүрний ихэс дээдсээс гаралтай гүнжийн нэр нөлөө, удам угсаа Унгернд чухал байсан учир гэрлэлт нь улс төрийн зорилгыг илүү агуулж байсан хэмээн хожмын түүхчид дүгнэжээ. Үнэндээ ч барон эхний бөгөөд эцсийн удаагаа гэрлэсэн нь тэр байсан бөгөөд хуримламагц Харбинаас нэн даруй Даурт буцан одсон ба жилийн дараа Монголд орохынхоо зүг өмнөхөн, 1920 оны IX сард гэрлэлтээ цуцлуулах тухайгаа Харбинд байсан баронесса Елена Павловна (орос нэр нь -Н.Х)-д мэдэгдэн элч илгээжээ. Үүгээр Унгерний хувийн намтрын нэгээхэн хэсгийг төгсгөж, Монголд хэрхэн холбогдох тухайд авч үзье.

Түүхийн ном зохиолоос үзвэл барон Унгерн нь Монголд гурван удаа ирсэн мэт байна. Академич Б.Ширэндэв агсан түүнийг "... 1910 онд Хүрээн дэхь хаант Оросын консулын хамгаалах ангид цэргийн алба хааж байсан"<sup>8</sup> хэмээн бичжээ. Энэ мэдээг бусад түүхчид мөн дурдсан байх боловч чухам иш татсан уг баримтыг заасан нь үгүй байна. Бид ч мөн энэ талаар холбогдох мэдээ сэлтийг архиваас олж чадаагүй бөгөөд гагцхүү Унгерний амьдралын хуудаснаас эрж хайх аваас, өгүүлэн буй 1910 он нь барон Даур дахь Аргуны хорооноос Амарын

<sup>4</sup> Витольд Ст Михаловски. Барон Унгерний алт эрдэнэс ( Бароны гэрээс) УБ., 1995. т.23.

<sup>5</sup> Л.Юзефович. Самодержац пустыни. Феномен судьбы барона Р.Ф.Унгерн-Штернберга. т. 35.

<sup>6</sup> Мөн тэнд т.44.

<sup>7</sup> Элбек-Доржи Ринчино о Монголии. Избранные труды. Улан-Удэ, 1998. с.232.

<sup>8</sup> Б.Ширэндэв. Монгол ардын хувьсгалын түүх. II удаагийн хэвлэл. УБ., 1999. т.156.

хороонд шилжин алба хаахаар явсан цаг үед тохиож байгаа юм. Энд, нэгэн зүйлийг анзаарахад Унгерн шинэ албаны газарт очих үедээ Аргуны хорооны офицерүүдтэй тавьсан мөрийгөө биелүүлсэнийг бодолцвол тэрээр Монголд бус, харин томилогдсон газартаа хүрсэн байна. Тэнд Оросын Ази, Манжуураар бүтэн жилийн турш ганцаар хэрэн тэнэхдээ буддын шашинд орж, монгол хэл үзсэн хэмээн зарим нэгэн зохиолд<sup>9</sup> дурдсан байх боловч чухам дээрхи мэдээнд холбогдох, тодруулах баримт Унгерний талаар гарсан бусад ном бүтээлд, нэн ялангуяа дурдатгал зохиолдуудад үгүй байна. Энэ бүхэн нь Унгерн 1910 онд Монголд ирсэн гэх магадлалыг ихээхэн хомс болгож байгаа хэдий ч хожмын нэгэн цагт холбогдох баримт олдохыг үгүйсгэх аргагүй.

Харин 1913 онд Монголын баруун хязгаарын Ховдод очсон тухайд бол түүхэнд тодорхой бөгөөд энэ тухай түүхчид судлаачид олонтаа өгүүлсэн билээ. 1913 оны VIII сард Монголын нийслэл – Хүрэнээс 700 мод газрыг туулан Улиастайд ирж өөрийнх нь тухайн аялалын талаар анх бичсэн А.В.Бурдуковтой уулзахаас өмнө Унгерн Хятад ба Монгол дахь үйл явдлын талаар сонин хэвлэлээс мэдэж байжээ. Тэгэх тусмаа Хүрээнд орос сургалттай цэргийн сургууль нээгдэж оросын сургагчид ажиллах болсоныг сонсмогц Монголд явуулахыг хүссэн боловч татгалзсан хариу авчээ. Монгол нь Унгерний хувьд ямагт “аугаа их байлдан дагуулагчдын эх орон” байсан учраас тэрээр хувийн журмаар ч болов Монголын цэрэгт алба хаахыг мөрөөдөж, 1913 оны VII сард “ ар гэрийн гачигдлын улмаас Эзэн хааны цэргийн албыг үргэлжлүүлэх боломжгүй” болсоноо учирлан чөлөөнд гаргахыг хүссэн өргөдөл илгээжээ. Урьд нь японы дайнд амжаагүйн адил үйл явдал болохоос эмээсэн барон Петербургт илгээсэн өргөдлийнхөө хариуг ч хүлээлгүйгээр Монголыг чиглэсэн бөгөөд Амарын хорооноос хэрхэн ямар замаар ирсэн нь тодорхойгүй. Гэхдээ л Амураас Монголын хил хүрч, тэндээс Хүрээ хүртэлх газрыг бүхэлд нь туулан, Улиастайд давхиж ирсэнийг бодвол түүний яарсаныг ойлгож болно.

Чамгүй урт замыг туулан, “сайн дураараа чөлөөнд гарсан дэслэгч Роман Феодорович Унгерн-Штернберг бол эрэлхэг гавъяа байгуулах үйл хэргийг хайж баруун зүгт аялах болсон тул энэхүү үнэмлэхийг Амар мөрөн дэхь хасаг цэргийн хорооноос олгов”<sup>10</sup> хэмээсэн бичиг өвөртлөн ирсэн барон Улиастайд сааталгүй Ховд хүрэхээр машинд яарч 450 мод буюу 15 өртөө газрыг гурав хүрэхгүй хоногт туулжээ. А.В.Бурдуков түүний байр байдлыг “хагсгал туранхай, ноорхой, салан унжуу эр бөгөөд нүүрэнд нь өрөвгөр шар сахал ургачихсан, гандмал мэлэрсэн хөх нүдтэй, гуч орчим настай болов уу гэмээр. Цэрэг хувцас нь ер бусын муухай, өмд нь ихэд элэгдэн, өвдгөөрөө цоорсон ажээ. Ташаандаа сэлэмтэй, бүсэндээ гар буутай” гээд дайны хэнээ туссан амьтан хэмээн тодорхойлсон байдаг. Тэрээр зам зуураа улаачид уураа гарган, ядрахыг үл мэдэн яаран давхиждаа А.В.Бурдуковоос Дамбийжанцангийн талаар лавлан асууж, түүнтэй хамтран хятадтай байлдах тухай ярьж, монгол үг тэмдэглэж авч хэлж сурахыг оролдож явжээ. Ховдын консул В.Ф.Люба, орос цэргийн отрядын дарга хурандаа Казаков нар Унгернийг Жаа ламтай нэгдэхийг эрс хориглосон учир Монголын цэрэгт алба хаших хэмээсэн түүний хүсэл биелсэнгүй. Гэхдээ Унгерн тэр даруй нутаг буцсангүй, хагас жил орчим Ховдод байж хятад, монгол хэл үзэн, монголчуудын зан заншил, ахуй амьдралтай танилцсан тухай түүхэнд бичиглэн үлдээжээ. Чухам энэ үеэс Дорно дахинд бишрэх түүний хүсэл тэмүүлэл эргэлт буцалтгүй тогтож, долоон жилийн хойно их үйлсийг зарлан Монголд дахин ирэх бодлын

<sup>9</sup> А. Столыпин. Нэр дурдсан зохиол. т.52.

<sup>10</sup> А.В.Бурдуков. Хуучин ба шинэ Монголд (Дурдатгалууд). УБ., 1987. т. 99.

үзүүр эхэлсэн болов уу. Мөн оныхоо өвөл чөлөөнд гарсан тухай баримт бичгээ авсан тэрбээр нутаг буцжээ.

Унгерний амьдралын сүүлийн он жил мөн л Монгол оронтой холбогдоно. Орос орныг хамарсан цагаантны хөдөлгөөн дарагдаж, иргэний дайн төгсгөлдөө орсон 1920 оны хавар улаан арми Өвөр Байгалийг чөлөөлж, зөвлөлтийн удирдагчид АДБНУ-ыг байгуулсанаар Чита ба Хятадын хилийн хооронд орших Даур станцад байсан Семенов, Унгерн нарыг улаантнаас зугатах гарц хайхад хүргэв. Семёнов Манжуурыг чиглэн хөдөлмөгч барон Унгерн 1919 оны эцсээр Монголд шууд цөмрөх төлөвлөгөөг нь тасалдуулсан хятад генерал Слю Шүжаны устгасан автономит засгийг сэргээх нэрийдлээр Монголыг зүглэсэн билээ.

Өрнөдийн соёл иргэншилд урам нь хугарсан Унгерн хаант Орос хувьсгалаар арчигдан үгүй болсоныг үл тэвчин, гагцхүү "Монгол нь Хятад, Орос, Европын хаант засгийг сэргээх гол түшиц газар болох ёстой"<sup>11</sup> бөгөөд "чухамхүү тэндээс л шинэ ертөнцийн бүтээн босголт эхэлнэ" хэмээн эцсийн найдвар өвөрлөн хөдлөхдөө тус орны тухайн цагийн улс төрийн байдал, нийгмийн сэтгэлгээ өөрт нь таатай боломжийг олгохыг ч мөн тооцоолсон байсан нь лавтай. Үнэхээр ч тусгаар байдал, хаант ёсны илэрхийлэл болж байсан автономит засгаа устгуулсан монголчууд тусламж эрэлхийлэн хэнд ч хандахад бэлэн байсан нөхцөл байдал нь эзэн хаант засгийг нийгмийн байгууллын хамгийн шилдэг хэлбэр хэмээн шүтэн бишрэгч Унгернд үзэл бодол, улс төрийн зорилгоо хэрэгжүүлэх орон зайг буй болгож, тэрээр хоёрдахь удаагаа Монголд иржээ. Энэ удаа тэрбээр урьдах шигээ дан биеэр бус, харин тус бүрдээ 150-200 хүнтэй монгол-буриадын, татаарын, атаман Анненковын гэсэн гурван морьт хороо, пулемётын команд бүхий Даурын морьт отряд, бүрэн бус гурван батареи бүхий 800-аад цэргийн хүч захиран Монголын хязгаарт нэвтэрч, "Богд гэгээнтнийг хаан ширээнд залж, автономит засгийг босгоно", "монголчуудыг хятад цэргээс чөлөөлнө", "Их Монгол улсыг байгуулна" зэрэг сүржин үг гарган, хятад цэрэг дургүйцсэн монгол ноёдыг өөрийн талд татахыг хичээнгүйлэн оролдож, Богд гэгээнд элч заран захидал илгээжээ. Захидалд "Оросын хаан угсааны барон Унгерн би Монголын язгуурын найртай сайны ёсоор Богд хаанд тус хийж, Монголыг харгис хятадын дарлагдлаас ангижруулан хамгаалж тохинуулахын тухай цэрэг авч Хүрээнд орох зорилго бүхий"<sup>12</sup> гэж мэдэгдэн, "Монголын автономитийг босгоход идэвхийлэн оролцож, монголчуудад их буу 7, винтов 4000-ыг өгөх ба эрт цагт их Чингис хаанд захирагдаж агсан үндэстнүүдээс бүрдсэн цэргийн хамтаар Монголын харъяат болоход бэлэн байгаагаа илэрхийлж"<sup>13</sup>, Хүрээ орох зөвшөөрөл хүсчээ. Цагаантны сургаар хятад цэргийнхэн монголын эрх баригчдыг буруутгах болсон нөхцөлд Богд гэгээн уг захидлыг хүлээн авсанаар үл барам орос цэргийг уг зорилтоос няцалт буцалтгүйгээр үтэр түргэн орж ирэхийг шаардан ирүүлэх даалгавар бүхий нууц түшмэл томилж байжээ. Түүнчлэн ЗОУ-аас ирсэн Д.Бодоо нар явсан хэргийн тухай Богдод айлтгасаны дараагаар зүүн зүг явж Унгерний цэрэгт орж ажилласан нь ч тохиолдлын зүйл байсангүй гэлтэй. Энэ бүхэн нь харийн цэргийн хоёр хүчийг хооронд нь тэмцэлдүүлж завсарт нь автономитыг босгох өөрсдийн зорилгоо гүйцэлдүүлэхийг хичээсэн бодлого байсны гэрч болов уу. Чухам үүний учир нутгийн эрх баригчид цагаан цэргийг нутаг хязгаартаа оруулснаар үл барам агт морьдыг нь арчлан, хүнс хөрөнгөөр тусалж эхэлжээ. Тэрээр Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошууны тэргүүн

<sup>11</sup> С. К. Рошин. Политическая история Монголии. 1921-1940. М., 1999. т. 10-11.

<sup>12</sup> Н. Магсаржав. Монгол улсын шинэ түүх. УБ., 1994. т. 175.

<sup>13</sup> УТА. ф. 445 д. 1. хн. 8. хуудас 9

захирагчид нь хил даван зугатжээ. Богд гэгээн Унгернд хошой чин ван цол шагнаж, дагалдагсдыг ч нэгэн адил хөхүүлжээ.<sup>16</sup>

Барон Унгерн өмнө зүгийн байлдааны үед Хятадын хилд тулж очсон ч Бээжинг зүглэснгүй, Хүрээнд буцаж "тохинуулан төвхнүүлэх" үйл ажиллагаагаа эхэлсэн нь тэрбээр Монголд орсныгоо "дэлхий дахины ач холбогдолтой зүйл"<sup>17</sup> хэмээн үзэж байсантай холбогдох болов уу. Монгол цэрэгтэй хавсран ялалт байгуулсан Унгерний зэвсэг хэрэгсэл, мөнгө санхүүгийн арвин нөөцтэй болсны дүнд нэр нөлөөгөө бэхжүүлэх, цэргийнхээ хүчийг зузаатгах зорилгоор зарим нэгэн арга хэмжээг авчээ. Эн түүрүүнд Богдын засгийн газрыг гадаад улсуудаар хүлээн зөвшөөрүүлэхийг оролдож, улсын санхүүг тогтворжуулах зорилгоор банк байгуулан 250,000 долларын богино хугацааны "болзоот мөнгө"-ийг гаргав<sup>18</sup>. Хүрээнд оёдол, засварын газар нээж, Налайхын уурхайг сэргээн ажиллуулав.

Гэвч өгүүлэн буй үед аллага хядлага цагаан цэргийн өдөр тутмын тогтмол үйл ажиллагаа болж, түүнд зөвхөн еврей, большевик үзэлтэй оросууд төдийгүй монголчууд ч өртөх болжээ. Зүсэн зүйлийн үндэс угсаатай цагааны дээрэмчдийн харгислал, жигшүүрт үйлийн тухай няцаагдашгүй баримт өдий төдийгөөрөө бий. Тэд "ядуу буурай, лам хар, эр эм, хөгшин залуу, хүүхдийг хүртэл энд тэнд дүүжлэн алсан нь нүд халтирмаар байсан" учраас үйл явдлыг нүдээр үзэгчид "Өргөө дэхь цуст хядлага" хэмээн нэрлэсэн буй за. Нийслэл Хүрээнээс цаашлах тусам цагаантнууд бүлэг дээрэмчид болон хувирч, бэлчээр усыг сүйтгэн, жингийн цувааг дээрэмдэж байв. Унгерний дэглэм тогтсоноор цагаантны хэсэг бүлгүүд Монголын хил хязгаарт цугларч, Алтай, Ховд, Хатгал, Дайчин вангийн хүрээ зэрэг газарт хоргодон суусан Кайгородов, Казанцев, Казагранди нар өндийн босч ард олныг дээрэмдэн тонох явдлыг газар сайгүй дэлгэрүүлжээ. Хөвсгөл нуурын орчимд Андрей Шубин, Хэрлэн Ононгийн сав газарт Туванов, Очиров нарын гэх цэрэг анги буй болж нийтдээ 2300-2500 орчим цагаантан Унгерний захиргаанд нэгдэж, хүчин хавсрахыг зорьж байлаа. 1921 оны IV сарын 14-нд Унгернээс 19-45 насны буриядуудыг өөрийн цэрэгт татах тушаал гаргаж, үл дагагсдыг хатуу ширүүнээр залхаан цээрлүүлэхээр заажээ.

Үүнээс илүү аюул байсан нь цаг үе, үйл явдлын нөлөөн дор монголын эрх баригчид Унгернд хүчин зүтгэж, аймаг хошуудаас цэрэг татаж байсан явдал юм. Тухайн үед Богдын лүндэнгээр Түшээт хан, Сэцэн хан, Шавь гурван газраас тус бүр нэг мянган цэрэг татахаар тогтож, Хатанбаатар С.Магсаржавыг баруун хоёр аймгийн цэргийг дайчлан захирах сайдаар, гүн Л.Гомбо-Идшинг зүүн хязгаарын сайдаар тус тус томилон илгээжээ. Унгерн мөн Жаа ламыг ихэд урьсан боловч харин тэрээр ирээгүйгээр үл барам Хүрээнийхнийг баронтой сүлбэлдлээ хэмээн дүргүйцэж байсан<sup>19</sup> аж. Албадлага дарамт, ов мэх, сүр хүчээр далайлгасан Унгерн цэргийн хүчээ монголчуудаар зузаатгах зорилгодоо хүрч чадсан бөгөөд Богдын лүндэнг дагасан, хөлс хүчинд хууртагдсан монголчууд нэг хэсэгтээ л улс үндсээ хэмээн идэвхийлэн байлдаж явжээ. 1921 оны дунд үеийг хүртэл Унгерний удирдлагад Лувсанцэвээн тэргүүн, Сундуй гүн, Балжинням гүн, Баяр гүн, бэйс Дугаржав, Найдан ван, Дарь эх лам, түшмэл Гэлэг-Ёндон нарын тэргүүлсэн 4000-аад монгол цэрэг захирагдаж явсан бөгөөд нийт цэргийн 2/3 нь монголчууд байсныг сүүлийн үеийн судалгаа харуулж байна. Хэдийгээр хятад цэргийг хөөн зайлуулахад Унгерн тодорхой үүрэг гүйцэтгэсэн ч түүний цаашдын зорилго, үйл ажиллагаа, нэн ялангуяа монголчуудыг өөртөө татах бодлого нь ихээхэн хор уршигтай байв. Бүтэн хоёр жилийн турш хятад цэргийн дээрэм

<sup>16</sup> УТА. Ф.А-4. хн. 790. нугалбар 32.

<sup>17</sup> Л.Юзефович. Нэр дурдсан зохиол. т. 14.

<sup>18</sup> И.Д.Першин. Барон Унгерн. Урга и Алтанбулак. Самара., 199. с.138.

<sup>19</sup> А.В.Бурдуков. В старой и новой Монголии. (Воспоминания и письма). М., 1969. с. 399.



тонуулд туйлдаж ядарсан Монгол орныг Унгерн өөрийн дэглэм, дайчилгаа албадлага, сүрдүүлгээрээ үнэхээр зутраажээ.

Унгерний үнэн нүүр царайг монголчууд тун удалгүй ойлгож эхэлжээ. Монголын төр, шашны тэргүүн Богд гэгээн ба Унгерний хоорондын харьцаанд ан цав гарч, Богдоос Унгерний үйл ажиллагаанд ихээхэн болгоомжтой хандах болжээ. Төрийн эрх баригчид ч бүгд дуулгавартай гүйцэтгэгчид байсангүй. Нөгөөтэйгүүр Монголын умард хэсэгт эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө монголчууд босч, Унгернд бут цохигдон очсон хятад цэргийг Хиагтаас хөөн зайлуулж, Үндэсний хувьсгалт түр засгийн газрыг байгуулан эх орноо бүрэн чөлөөлөх тэмцэлд бэлтгэж эхэлсэн байв. Дээрхи үйл явдлуудын нөлөөгөөр монголчууд Унгернийг "Авран чөлөөлөгч" гэхээсээ илүүтэйгээр түүнээс холдон салж, хөндийрөхийг эрмэлзэх болов. Цаашид монголчууд түүнтэй нэг замаар явахгүй гэдгээ харуулсан бөгөөд өөрөө ч түүний байр суурь төдийлөн бат бэх бус болсныг ойлгосон нь тодорхой. Ерөөс Монголд Унгерн хир их нөлөөтэй байсныг нэг үгээр тодорхойлоход бэрхшээлтэй бөгөөд цаг хугацааны хувьд ялган салгаж харах нь зүйтэй. Мэдээжээр эхний сард түүний нэр хүнд нөлөө өндөр байсан бол цаашид тийнхүү тодорхойлж үл болно. Үүний жишээ нь хожим мөрдөн байцаалт дээр "...би Монголын хэрэг явдлаас хол байхыг хичээж байсан, гэхдээ миний цэрэг Монголд байсан учир бас оролцох хэрэгтэй болсон"<sup>20</sup> гэсэн бол дараа удаа нь "улс төрийн нөлөөгүй байсан" гэснээс харагдана. Тулах түших хүчгүй болсон Унгернд Монголд үлдэх шалтгаан байсангүй.

Тэрээр үйл ажиллагааныхаа чиглэлийг өөр зүгт хандуулахаар шийдэж, 1921 оны Ү сарын 20-нд Бээжин дэхь агент Грегорид бичсэн захидалдаа "...миний бие ойрын үед большевикуудын эсрэг цэргийн үйл ажиллагаа эхэлнэ. Коммунизмтэй тэмцэхийг мөрөөдөгч бүх отрядуудад шийдвэрлэх түлхэц өгсний дараагаар Орост бослого эхэлж, түүний толгойд итгэлтэй үнэнч хүмүүсийг тавимагц үйл ажиллагаагаа Монголд шилжүүлж, Чин улсыг сэргээхэд чиглүүлнэ..."<sup>21</sup> гэснээс үзэхүл большевизмын эсрэг тэмцлээ эхэлсэн мэт боловч үнэн хэрэгтээ Монголд өдрөөс өдөрт унаж байсан нэр төрөө аврах хэмээн нэгэн адил оролдсон гэж үзүүштэй. Тийм ч учраас Зөвлөлт Сибирийн нутагт байсан цагаантны бүх отрядуудад хандаж нэгдэхийг уриалсан "15-р тушаал"-аа гаргаж 1921 оны Ү сарын 21-нд Нийслэл Хүрэннээс умар зүг хөдөлсөн билээ. Гэвч цагаантныг манлайлан давшсан Баяр гүний анги Алтанбулагт жанжин Д.Сүхбаатарын удирдсан ардын журамт цэрэгт бут цохигдон, Дарь эх ламын цэрэг бууж өгсөн хэрэг үйл явдал болж, зургаадугаар сарын дундуур хилийн районд Унгерний биечлэн захирсан үндсэн хүч монгол-оросын цэрэгт бут цохиулан сарнижээ. Тэрээр Монголын умард хэсэг Вангийн хүрээний чиглэлд байрлан ЗОУ-ын нутаг дэвсгэрт цөмрөхийг хэдэнтээ оролдсон боловч амжилт олоогүй бөгөөд хамгийн сүүлд 1921 оны VIII сарын 14-нд Монголд буцаж оржээ. Чухам энэ үеэс үргэлжийн хуйвалдаан, самуунд автагдсан цагаантны хүч бутран сарниж, бароны шадар туслагч генерал Резухин алагдаж, монголчуудаас зөвхөн Сундуй гүний дивизион л үлджээ. Унгерн үлдсэн 500-аад цэргээ авч Жалханзын Хүрээний хавьд буудалласан үед түүний эсрэг хуйвалдаан гарч, цагаан цэргийн сумнаас мултарсан тэрбээр Сундуй гүний монгол цэрэгт ирж нийлжээ. Гэвч түүний хувь тавилан нэгэнт шийдэгдсэн байлаа.

1921 оны VIII сарын 22-нд одоогийн Хөвсгөл аймгийн Тариалан сумын төвөөс баруун тийш орших Зүлэгтийн голын эхний цутгал, Жаргалантын амны

<sup>20</sup> С.К.Рощин. нэр дурдсан зохиол. т. 13.

<sup>21</sup> Materials about Baron Ungern-Steernberg (Collected by John Jennings at Hoover Archives), Order No. 15.

эхэнд орших Гангын үзүүр хэмээх газар Сундуй гүн өөрийн цэрэг Дэмид, Лувсан-Очир нарын хамтаар Унгернийг хуурмаглан барьж аваад К.К.Рокоссовскийн 35-р хорооны цэрэгтэй тохиолдон тушаан өгчээ. Бароныг баривчилсан, шилжүүлэн өгсөн хийгээд улаан цэргүүд анхлан түүнийг танихгүй байсан гэх зэргээр эл үйл явдлын тухай олон янзаар бичсээр ирсэн боловч Унгерн олзлогдож, түүний Монгол дахь үйл ажиллагаа төгсгөл болсон нь бодит зүйл байлаа. Олзлогдсон Унгернийг Троицкосавск дахь Аялан байлдах корпусын штабт хүргүүлэн Дээд-Үд, Эрхүүгээр дамжуулан Новониколаевскт аваачин шүүхээ<sup>22</sup>. 1921 оны IX сарын 15-нд ЗСБНХОУ-ын Хувьсгалт цэргийн онцгой шүүхээс “Азийн морин дивиз”-ийн захирагч, дэслэгч генерал Р.Ф.Унгерн фон Штернбергт цаазаар авах ял оноон мөн өдөр нь гүйцэтгэжээ. Новониколаевскийн Сосновка цэцэрлэгт хүрээлэнгийн театрт олон нийтийн өмнө Унгернийг шүүхэд тэрбээр урагдаж муудсан шар дээл, монгол гуталтай байсан; хожим нь түүнийг цаазалсан тухай мэдээ Хүрээнд ирэхэд Богд гэгээний лүндэнгээр хүрээ хийдэд маанийн ерөөл уншсан гэдэг. Энэ бүхэн нь барон Унгерн хувь заяаны эрхээр Монгол оронтой холбогдсоны сүүлчийн илрэл байлаа. 1920 оноос хойш 2 жил гаруй үргэлжилж, хагас сая хүнийг хамарсан цагаантны хөдөлгөөний удирдагчид генерал М.В.Алексеев, П.Н.Врангель, А.В.Деникин, А.И.Драгомиков, Л.Г.Корнилов, адмирал А.В.Колчак нарын нэрсийн дунд хаант Оросын армид алба хашигдаа зуутын даргаас дээш яваагүй Унгерн фон Штернбергийн нэр үгүй нь түүнийг Монголын үйл явдал түүхэнд гаргаж ирсэнийг нотолном.

#### Ашигласан ном зохиол

- 1.Бурдуков.А.В. В старой и новой Монголии. Воспоминания и письма. М., 1969.
- 2.Бурдуков.А.В. Шинэ ба хуучин Монголд. УБ., 1987.
- 3.Витольд Ст.Михаловски. Барон Унгерний алт эрдэнэс. УБ., 1995.
- 4.Bloody Baron "The Story of Ungern-Sternberg" by Vladimir Pozner. Random House.New York. 1938.
- 5.Марсаржав.Н. Монгол улсын шинэ түүх. УБ., 1994.
- 6.Materials about Baron Ungern-Steernberg (Collected by John Jennings at Hoover Archives). Order No. 15.
- 7.Оссендовски.Ф. Хүн, араатан, бурхад УБ., 2000.
- 8.И.Д. Першин "Барон Унгерн, Урга и Алтанбулак" Самара 1999.
- 9.Пэрлээ.Х. Эрдэм шинжилгээний өгүүллүүд". Б.1. УБ., 2001. 8
- 10.Роцин.С.К. Политическая история Монголии. 1921-1940. М., 1999.
- 11.Столыпин.А. Москва Бээжингийн завсар дахь Монгол орон.УБ., 2000.
- 12.Үндэсний төв архив. ф.А-4. хн. 790.
- 13.Үндэсний төв архив. ф.445. хн.8.
- 14.Форбат.Л. Өргөө дэхь цуст хядлага. УБ., 1992.
- 15.Хишигт.Н. 1921 оны хувьсгал ба ардын журамт цэрэг. УБ., 2001.
- 16.Ширэндэв.Б.Монгол ардын хувьсгалын түүх. II удаагийн хэвлэл. УБ., 1999.
- 17.Юзефович.Л.Самодержац пустыни. Феномен судьбы барона Р.Ф.Унгерн-Штернберга. М.,1993.
- 18.Элбек-Доржи Ринчино о Монголии. Избранные труды. Улан-Удэ., 1998.

<sup>22</sup> Н. Хишигт. 1921 оны хувьсгал ба ардын журамт цэрэг. УБ., 2001. т-121.